



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ ДАРГА С.ДАВААСҮРЭН  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон

Утас: 26-70-16, Факс: 32-70-16

E-mail: [stategreathural@parliament.mn](mailto:stategreathural@parliament.mn)

<http://www.parliament.mn>

2019.10.16 № 29

Асуулга тавих тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, 33 дугаар зүйлийн 33.1.2-т тус тус заасан бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуулгыг Танд тавьж байна. Үүнд:

1. Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн талаар: Тус хуулийг хэрэгжүүлж, ач тусыг нь олон түмэнд хүргэж, сурталчлан таниулахад чухал үүрэгтэй Таны удирдсан Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ) хуулийн хэрэгжилтийг хангах, сайжруулах, түүнийг сурталчлан таниулах чиглэлээр ямар арга хэмжээ авч, ямар үр дүнд хүрсэн бэ? Тус хуулийн ачаар хэдэн иргэн, аж ахуйн нэгж зам, тээврийн ослын улмаас учирсан хохирлоо нөхөн төлүүлж чадсан байна вэ? Иргэд, аж ахуйн нэгжийн тоо, нөхөн төлбөрийн хэмжээний тоон мэдээллийг жил бүрээр нь гаргаж ирүүлнэ үү;
2. Жолоочийн даатгалын тухай хуулийг Та хэрхэн үнэлж байна? Хуулийн ямар зүйл, заалт амьдралд нийцэхгүй, хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна вэ? Хуулийг сайжруулах тухай холбогдох саналаа Та УИХ-д, түүний Байнгын хороод, гишүүдэд хүргүүлж байсан эсэх;
3. УИХ-ын 2017 оны 11 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн 81-д "Улсын Их Хурлаас 2011 онд баталсан Жолоочийн хариуцлагын даатгалын тухай хуулийн хэрэгжилтэд үндэслэн энэ төрлийн даатгалын зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг нарийвчлан зохицуулах, даатгуулагчийн хариуцлагыг сайжруулах" зорилтыг дэвшүүлж, 2017 онд багтаан хууль санаачлахыг Засгийн газарт, хуулийн төслийг хариуцан боловсруулахыг СЗХ-нд тус тус даалгасан байна. Гэтэл 2019 он дуусахад 3 сар, УИХ-ын бүрэн эрхийн хугацаа дуусахад 9 сар хүрэхгүй хугацаа үлдээд байхад хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлээгүй байгаагийн буруутан нь Засгийн газар уу, СЗХ юу? СЗХ хуулийн хэрэгжилтэд цогц үнэлгээ өгч, даатгагч, даатгуулагч, зуучлагч зэрэг сонирхогч талуудтай зөвлөлдсөн үү? Улмаар хуулийн төслийг хариуцан боловсруулж Засгийн газарт хүргүүлсэн үү? Энэ ажлыг хийгээгүй бол яагаад хийгээгүйгээ тайлбарлаж өгнө үү;
4. Жолоочийн даатгалын тухай хуулийн үндсэн зорилгын нэг нь зам тээврийн осол, замын хөдөлгөөний дүрмийн зөрчил гаргаагүй жолооч нарын хариуцлагын даатгалын хураамжийг жил бүр бууруулах, бүхий л хэлбэрээр урамшуулах, зөрчил гаргасан жолооч нарын хураамжийг нэмэгдүүлэх зэрэг санхүүгийн хөшүүрэг ашиглаж, жолооч нарыг хариуцлагажуулах явдал юм. Тиймээс хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2-т "өмнөх гэрээний хугацаанд даатгуулагчийн буруугаас үүссэн даатгалын тохиолдлын тоо, олгосон нөхөн төлбөрийн хэмжээ"-г харгалзан

0000000114

даатгалын хураамжийн хэмжээг нэмэгдүүлэх буюу хорогдуулан тооцож байхаар, мөн зүйлийн 11.2-т "Даатгалыг хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална" гэж заасан. Гэтэл өнгөрсөн хугацаанд СЗХ хуулийн энэ чухал зорилтыг огт ойшоолгүйгээр, зам тээврийн осол, зөрчил гаргасан эсэхийг нь ялгаж салгалгүйгээр нийт жолооч нараас хавтгайруулан жигд хураамж цуглуулж, улмаар хуулийн үзэл санаа, хууль тогтоогчийн бодлогыг гуйвуулж ирлээ. Түүгээр ч үл барам, СЗХ нь "Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам"-ыг хоёр ч удаа өөрчилж, Орхон, Дархан-Уул аймгийн даатгуулагчдын, мөн дамжин өнгөрөх тээврийн хэрэгслийн болон хуулийн этгээдийн даатгалын хураамжийг их хэмжээгээр нэмэгдүүлсэн байна. Эцсийн дүндээ даатгалын тохиолдол гаргаагүй даатгуулагчдын төлөх даатгалын хураамж өссөн дүнтэй байна.

Даатгалын компаниуд Жолоочийн хариуцлагын даатгалын хураамжаар өнгөрсөн 7 жилийн хугацаанд нийт 160,8 тэрбум төгрөг төвлөрүүлж, улмаар 40 гаруй хувь нь буюу 65,2 тэрбум төгрөг нь даатгалын компаниудын ашиг болж үлдсэн тооцоо гарчээ. Жолоочийн даатгалын тухай хуулийн зорилго нь даатгалын компаниудын ашиг орлогыг нэмэгдүүлэх биш, харин зам тээврийн ослын улмаас хохирсон иргэд, аж ахуйн нэгжийн хохирлыг аль болох бүрэн барагдуулах, жолооч нарын хариуцлагыг нэмэгдүүлж, зам тээврийн ослыг бууруулах явдал гэдгийг энэ дашрамд Танд дахин сануулахаас өөр аргагүй байна.

5. Автотээврийн хэрэгслийн өмчлөгч бүр жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдаж байж хохирогчдын хохирлыг аль болох бүрэн барагдуулах, даатгалын хураамжийн хэмжээг багасгах, жолооч нарыг хариуцлагажуулах хуулийн зорилт биелэх учиртай. Тийм ч учраас хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасны дагуу "тээврийн хэрэгслийн өмчлөгч бүр жолоочийн даатгалд заавал хамрагдах" нь энэ үйл ажиллагааны үндсэн зарчим болгож хуульчилсан. Гэтэл бидэнд байгаа бүрэн бус мэдээллээр автотээврийн хэрэгслийн өмчлөгчдийн ердөө 70 гаруй хувь л энэ даатгалд хамрагдаж байгаа юм байна. Хэрэв энэ тоо үнэн бол хамралт ийм хангалтгүй байгаагийн учир шалтгаан, эзэн хариуцагчийг хэлж өгнө үү? СЗХ нь нийт 15 даатгалын компани, орон нутаг дахь 238 салбар, 40 гаруй зуучлагч, 7 арилжааны банкинд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон хирнээ хуулийн хамгийн чухал зарчим, заалтыг хэрэгжүүлэх тал дээрээ хангалтгүй ажиллаж байна гэсэн дүгнэлттэй Та санал нийлж байна уу?
6. Автотээврийн хэрэгслийн өмчлөгч бүрийг даатгалд заавал хамруулах хуулийн заалтыг хэрэгжүүлээгүй хирнээ хуулиар даатгалд заавал хамрагдах ёсгүй буюу хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.3-т дурдагдаагүй этгээдийг даатгалд хамруулахаар СЗХ итгэлцүүрийн журам баталжээ. Ингэснээр даатгуулагчийн гэр бүлийн гишүүдийг даатгалын гэрээний хавсралтад нэр бичиж даатгалтай жолооч гэж үзэх эрх зүйн зохицуулалт бий болгож, улмаар "даатгагчтай гэрээ байгуулж замын хөдөлгөөнд оролцох үедээ бусад этгээдийн өмнө хүлээх хариуцлагаа даатгуулсан этгээд"-ийг даатгуулагч гэж хуулиар тодорхойлсныг зөрчиж байна. Ийм зохицуулалт хийх гарцаагүй учир шалтгаан байсан бол тодорхой тайлбарлаж өгнө үү.
7. Жолоочийн даатгалын хураамжийн орлогоос Жолоочийн даатгалын сан байгуулах, улмаар Албан журмын даатгалын сан байгуулахаар хуульчилсан. Өнгөрсөн хугацаанд Жолоочийн даатгалын санд нийт хураамжийн орлогын 1,8 хувийг буюу 3,0 тэрбум төгрөг төвлөрүүлжээ. Жолоочийн даатгалын санд байршуулсан хөрөнгөөр зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг багасгах, жолоочийн даатгалын мэдээллийн сан хөтлөхөд зарцуулагдах ёстой. Гэтэл хураамжийн орлого нь дээрх үйл ажиллагааг явуулахад

0000000114


зарцуулагдах ёстой. Гэтэл хураамжийн орлого нь дээрх үйл ажиллагааг явуулахад хүрэлцэхгүйн улмаас төрийн санхүүжилтээр хэрэгжүүлж байна. Жолоочийн хариуцлагын даатгалын хураамжийн орлогоор жолоочийн даатгалын сан бүрдүүлэх тал дээр СЗХ ямар санал, санаачилга гаргасан бэ?

8. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8-р зүйлийн 6.18 дахь хэсэгт зааснаар Жолоочийн даатгалын тухай хууль зөрчигчдөд хариуцлага тооцож, хуулийн хэрэгжилтийг хангах үүрэг СЗХ-нд ногдож байна. Өнгөрсөн хугацаанд СЗХ-ны хянан шалгагчид энэ хуулийг зөрчсөн хэдэн удаагийн үйлдлийг илрүүлж, акт тавьж, нийт хэдэн төгрөгийн торгууль ногдуулсан байна?

Эдгээр асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан хугацаанд бичгээр ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Ц.МӨНХ ОРГИЛ

0000000114